

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар

Сарын 12-ны өдрийн 505 дугаар тогтоолын хавсралт

## **“ХОРГО ХАЙРХАН” ХК-ИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

### **I. ТАЙЛАНГИЙН ЭХНИЙ ХЭСЭГ**

#### **1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:**

Хорго Хайрхан Хувьцаат Компани

Хаяг: Төв аймаг, Эрдэнэсант сум, Хорго Хайрхан ХК

Утас: 99190032

Факс:

Электрон хаяг:

#### **2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:**

Улсын бүртгэлийн дугаар:

Регистрын дугаар: 2032317

Үйл ажиллагааны чиглэл: Газар тариалан, туслах үйл ажиллагаа

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 245

#### **3. Үнэт цаас гаргагчийн түүх, тухай зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:**

Тус компанийн эх үүсвэр нь анх 1937 онд Төв аймгийн Эрдэнэсант сумын нутаг “Царам” гэдэг газар өвс адах морин станц нэртэйгээр анх байгуулагдаж байсан.

1957 онд мал аж ахуйн машинт станц болон өргөтгөж улсаас өөрчлөн зохион байгуулсан. Мал аж ахуйн машинт станц байх хугацаандаа Төв аймгийн “Саруул Амьдрал”, “Хөгжлийн яам”, “Залуучуудын хөгжил”, “Бүрэн дэлгэрэх”, “Ялалт”, “Заамар” нэгдлүүдэд үйлчилж байсан.

1971 онд ЗХУ-ын хөрөнгөөр тэжээлийн аж ахуй болгон өргөтгөж байгуулагдсан. Тэжээлийн аж ахуй нь 20.5 мянган га эргэлтийн талбайтай, жил бүр 14,500 га-д үр тариа, төмс хүнсний ногоо тариалж, үр тарианы хадлангийн 5 бригадтай, малын 1 бригадтай үйлдвэрлэл явуулдаг байжээ. 15 морины хүчинд шилжүүлснээр 185 трактор, үр тарианы комбайн 60 гаруй, ачааны болон тусгай зориулалт бүхий бүгд 40 гаруй автомашинтай, хөдөө аж ахуйн төрөл бүрийн машин тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдан ажиллаж байсан.

Тэжээлийн аж ахуйд жилдээ 117 мянган тонн холимог тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэртэй байсан. Жилдээ 120 трактор засвар үйлчилгээ

хийх хүчин чадалтай засварын газар, 2,400 тоннын багтаамжтай үрийн агуулахтай.

1992 оноос тус аж ахуй нь аж ахуйн нэгжийг хуулийн дагуу “Буянттөв” ХК, “Хоргохайрхан” ХК болон шинээр зохион байгуулагдсан юм.

**4. Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл:**

Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Р.Ариунболд	ТУЗ-ийн дарга	19.9%
2	Р.Батболд	Гүйцэтгэх захирал	20.1%
3	О.Тунгалаг	ТУЗ-ийн гишүүн	27.5%
4	Б.Баатарцогт	Хувьцаа эзэмшигч	13.8%

**5. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:**

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	О.Тунгалаг	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
2	Р.Батболд	ТУЗ-ийн гишүүн /Гүйцэтгэх захирал/	Дээд	
3	П.Энхзориг	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
4	Д.Бадамдорж	ТУЗ-ийн гишүүн	Бүрэн Дунд	
5	Л.Энхбаатар	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
6	Д.Батбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
7	Р.Ариунболд	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
8	Д.Давгабазар	ТУЗ-ийн	Дээд	
9	З.Гаравсүрэн	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
10	З.Одбаяр	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Дээд	

**6. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:**

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	О.Тунгалаг	ТУЗ-ийн гишүүн	27.5%
2	Р.Ариунболд	ТУЗ-ийн дарга	19.9%
3	Р.Батболд	ТУЗ-ийн гишүүн	20.1%
4	Б.Баатарцогт	Хувьцаа эзэмшигч	13.8%

**II. ТАЙЛАНГИЙН ХОЁРДАХЬ ХЭСЭГ**

**1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:**

Компанийн 2012, 2013, 2014 оны орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он
Борлуулалт	33,141.7	5,781.6	-
Борлуулалтын хөнгөлөлт	-	-	-
Цэвэр борлуулалт	33,141.7	5,781.6	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	7,360.0		-
Нийт ашиг	25,781.7	5,781.6	-
Үйл ажиллагааны зардал	24,198.6	11,134.8	8,013.0
Үйл ажиллагааны ашиг /алдагдал/	1,583.1	7,678.8	-
Үйл ажиллагааны бус зардал	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	1,583.1	7,678.8	(8,013.0)
Орлогын татварын зардал	158.3	767.8	-
Цэвэр ашиг /алдагдал/	1,424.8	6,911.0	(8,013.0)

Компанийн 2012, 2013, 2014 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	2012 он	2013 он	2014 он
Эргэлтийн хөрөнгө	2,661.0	42.9	19.1
Эргэлтийн бус хөрөнгө	87,806.0	87,806.0	87,806.0
Нийт хөрөнгийн дүн	90,467.0	87,848.9	87,825.1
Богино хугацаат өр төлбөр	74,644.8	65,115.7	54,969.0
Урт хугацаат өр төлбөр	-	-	-
Эзэмшигчдийн өмчийн дүн	15,822.2	22,733.2	32,856.1
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	90,467.0	87,848.9	87,825.1

**2. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээр нь үнэт цаас эзэмшдэг талаарх мэдээлэл:**

№	Овог нэр	Цалин урамшуулалын хэмжээ	Хандив тусламжийн хэмжээ	Бусад	Эзэмшиж буй хувьцааны тоо
1	О.Тунгалаг	90,000₮	-	-	37,165ш
2	Р.Батболд	90,000₮	-	-	27,160ш
3	П.Энхзориг	90,000₮	-	-	-
4	Д.Бадамдорж	90,000₮	-	-	-
5	Л.Энхбаатар	90,000₮	-	-	-
6	Д.Батбаяр	90,000₮	-	-	-
7	Р.Ариунболд	90,000₮	-	-	26,915ш

8	Д.Давгабазар	90,000₮	-	-	-
9	З.Гаравсүрэн	90,000₮	-	-	-
10	З.Одбаяр	-	-	-	-

### 3. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

Компани нь одоогоор үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй байгаа бөгөөд шинэ төсөл хэрэгжүүлэх шатандаа ажиллаж байна. Иймд сүүлийн жилүүдэд хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг тараагаагүй байгаа ба жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар уг шийдвэрийг танилцуулж ирсэн болно.

### 4. Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаарх мэдээлэл:

“Хорго Хайрхан” ХК нь 2014 онд “Компанийн тухай хууль”-ийн 87, 89 дгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

### 5. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан:

№	Овог нэр	Эрхэлдэг ажил	Эзэмшсэн мэргэжил боловсрол	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь	Хараат бус гишүүн эсэх
1	О.Тунгалаг	Тэтгэвэрт	Дээд	37,165	Хараат
2	Р.Батболд	Гүйцэтгэх захирал	Дээд	27160	Хараат
3	П.Энхзориг	Чинтайх Трейд ХХК захирал	Дээд	-	Хараат бус
4	Д.Бадамдорж	ХАА-н механикч	Бүрэн дунд	-	Хараат
5	Л.Энхбаатар	Ня-Бо, эдийн засагч	Дээд	-	Хараат бус
6	Д.Батбаяр	МИГ даатгал ХХК менежер	Дээд	-	Хараат бус
7	Р.Ариунболд	ТУЗ-ийн дарга	Дээд	26,915	Хараат
8	Д.Давгабазар	Хөнөг нуур ХХК захирал	Дээд	-	Хараат бус
9	З.Гаравсүрэн	Эрхжин ХХК-ийн захирал	Дээд	-	Хараат
10	З.Одбаяр	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Дээд	-	-

Компани нь 2014 оны 04-р сарын 21-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг дахин сонгосон бөгөөд 2014 оны 05-р сарын 30-ний өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон:

- а. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Д.Давгабазар, Д.Батбаяр, З.Гаравсүрэн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр

байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Давгабазар-г томилсон.

- b. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулалын хороог Л.Энхбаатар, Д.Батбаяр, Д.Давгабазар гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Л.Энхбаатар-г томилсон.
- c. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог П.Энхзориг, Д.Батбаяр, З.Гаравсүрэн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн П.Энхзориг-г томилсон.

2014 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган баталж, 4 удаа ирц бүрдүүлэн хуралдаж ХЭХ-аас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу 10 асуудал хэлэлцэж нийт хэлэлцсэн асуудлаар 6 тогтоол, 6 тэмдэглэл гарган баталж, гүйцэтгэлд хяналт тавьж дүгнэж ажилласан.

Тайлангийн хугацаанд “Нэр дэвшүүлэх хороо” 2 удаа хуралдаж 3 асуудал, “Аудитын хороо” 2 удаа хуралдаж 2 асуудал, “Цалин урамшуулалын хороо” 2 удаа хуралдаж 2 асуудал тус тус хэлэлцсэн байна. ТУЗ-ийн хурлын дундаж ирц 88.96 % байсан.

ТУЗ-с гаргасан тогтоол, шийдвэр түүний биелэлтийг өөрийн компанийн цахим сайтуудаар цахим хэлбэрээр явуулж тайлагнаж ажилласан.

#### **6. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан:**

“Хорго Хайрхан” ХК нь сүүлийн жилүүдэд санхүүгийн хүндрэлтэй байдлын улмаас газар тариалангийн чиглэлээр бие даасан үйл ажиллагаа явуулж чадахгүйд хүрсэн ба тус компанийн тариалангийн талбай нь атаршиж, захаасаа элсний нүүдэлд баригдаж цаашид тариа тарих, уринш бэлтгэх боломжгүй болсон. “Хорго Хайрхан” ХК нь 1992 оны хувьчлалаар нийт 7,878 га эргэлтийн талбайтай байсан ба 2003 он хүртэл уг тайлбаг эзэмшиж байсан боловч үйл ажиллагаа явуулахгүй санхүүгийн хувьд хүндрэлтэй байдалд орсон тул уг газрыг орон нутгийн эзэмшилд буцаан шилжүүлэн өгсөн болно.

2009 оноос төр засгаас авч хэрэгжүүлсэн Атрын 3-р аян явагдаж хөдөө аж ахуйн газар тариалангийн салбар сэргэж тодорхой үр дүн гарч байгаа боловч “Хорго Хайрхан” ХК нь хуучин өр зээлийн асуудлаас шалтгаалан ямар нэг зээл хөнгөлөлтөнд хамрагдаж чадаагүй ба өөрсдийн хуучин эзэмшлийн газрыг авах боломжгүй болсон. Компани нь нийт 1,500 га талбайг өөрсдийн хүчээр авсан боловч эргэлтийн хөрөнгө мөнгө, тоног төхөөрөмжийн дутагдалтай байдлаас үүдэн уг газрыг буцаан шилжүүлсэн болно.

“Хорго Хайрхан” ХК-ийн нийт өр төлбөрийн хэмжээ 1990 оноос хойш хуримтлагдсаар нийтдээ 180-аад сая төгрөг болсон ба компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын баг сүүлийн хэдэн жилд уг өр төлбөрийг барагдуулах, компанийг санхүүгийн бэрхшээлээс гарах тал дээр нилээдгүй ажлыг хийн компанийн найдваргүй болсон авлага, өглөг, ашиглагдахгүй болсон, ашиглалтын хугацаа дууссан, тоногдож үгүй болсон үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмжүүдийг компанийн балансаас хасаж цэгцлээд байна.

Одоогоор Хорго Хайрхан ХК нь өөрсдийн үндсэн үйл ажиллагаа болох газар тариалан буюу үр тариа тарих ямарч боломжгүй болсон ба цаашдаа нэмэлт хөрөнгө оруулалт хийх замаар компанийн үйл ажиллагааг сэргээх, үйл ажиллагааны чиглэлийг мал аж ахуйн чиглэл рүү шилжүүлэн компанийн одоогийн байгаа объект, үл хөдлөх хөрөнгө дээрээ түшиглэн махны чиглэлийн эрчимжсэн цогцолбор байгуулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бага оврын үйлдвэр байгуулах зорилттой байгаа ба уг чиглэлийн дагуу компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

### **“ХОРГО ХАЙРХАН” ХК-ИЙН БОЛОВСРУУЛСАН ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

#### **Төслийн танилцуулга**

Төслийн нэр: “МАХНЫ ЧИГЛЭЛ ҮХЭР ҮРЖҮҮЛЖ, МАХ ҮЙЛДВЭРЛЭН БОЛОВСРУУЛАХ ЦОГЦОЛБОР АЖ АХУЙ”

Үйл ажилгааны үндсэн чиглэл: Бүтээмж ихтэй үхэр үржүүлж, мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

Төсөл хэрэгжих хугацаа: 2014-2017 он /цаашид үргэлжлэх/

Төсөл хэрэгжих газар: Монгол орны эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс нутаг буюу Төв аймгийн Эрдэнэсант сум

Төслийн эдийн засгийн үзүүлэлтүүд:

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоо ширхэг
1	Борлуулалтын орлого	сая.төг	1,949.80
2	Хөрөнгө оруулалтын нийт зардал	сая.төг	1,632.95
3	Цэвэр ашиг	сая.төг	285.17
4	Эргэн төлөгдөх хугацаа	жил	5.7

#### **Төслийн агуулга:**

Махны чиглэлийн эрчимжүүлсэн аж ахуй байгуулах ЖДҮ төслийг махны чиглэлээр төрөлжсөн арвин ашиг шимтэй үхэр үржүүлэх жишээн дээр

боловсруулсан. Үүнд махны чиглэлээр төрөлжсөн 1020 үхэр /үүнээс: үнээ 1000/- тэйгээр үйл ажиллагааг эхлэхээр тооцсон. Ээлжиндээ 10 толгой үхэр нядалж, хоногт 3.0 тн мах үйлдвэрлэх хүчин чадалтай мал нядалгааны газар, Хөргүүртэй зоорьтойгоор төсөвлөсөн.

Махны чиглэлээр төрөлжсөн үүлдрийн үхэр үржүүлэх учир цэвэр үүлдрийн /Монгол, Сэлэнгэ, Лимузин, Ангус/ худалдаж авна.

Төсөл хэрэгжүүлэгч нь махны үхрийн үржил, селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, технологийн дагуу явуулах, шилмэл хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж, өөрийн сүргийг сэлбэх, бусад аж ахуйн нэгж, иргэдэд худалдан борлуулах ажлыг зохион байгуулах юм. Тугал өсвөр үхрийг зохистой өсгөн бойжуулж бэлчээрээр маллах, бордох, 18 сартайд нь махны үйлдвэрт худалдах дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлж, мах үйлдвэрлэл орлуулалтын хоорондох урт хугацааг 10-20 сар нааш татах боломж бүрдэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх юм.

### **III. ТАЙЛАНГИЙН ГУРАВДАХЬ ХЭСЭГ**

Компани нь 2014 оны 04 сарын 21-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан
- b. Аудитын хорооны тайлан дүгнэлт
- c. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны цалин урамшуулал болон зардлын төсөв
- d. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- e. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх

Компани нь 2013 оны 11 сарын 15-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан дүгнэлт
- b. ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдийн танилцуулга
- c. Компанийн шинэчилсэн дүрмийн төсөл
- d. Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө
- e. Компанийн үнэт цаасны арилжааг сэргээх
- f. Компанийн засаглалын 5 журам батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэн баталсан болно.